ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Монгол Улсын их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/47/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimeg.ts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorj.s@audit.gov.mn

Ахлах аудитор: Г. Оюунтөгөлдөр
Утас: 261740 Цахим хаяг: oyuntuguldur.g@audit.gov.mn

Мэдээлэл Аудит ХХК-ийн Захирал Д.Товуудорж
Утас:70159511, 99049511
Цахим хаяг: medeelelaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТБУСАУДИТОРЫНДҮГНЭЛТ....3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....11
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл ....12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт ....15
4. АУДИТЫН ТАЙЛАН....19
4.1 Ерөнхий зүйл ....19
4.2 Материаллаг байдал....19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ....19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....20
4.5.1 Завсрын аудитын талаар ....20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн....21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....22
5.1 Төлбөрийн акт ....22
5.2 Албан шаардлага ....22
5.3 Зөвлөмж....23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....25
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл....25
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл ....25
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....27

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| ААНОАТ | Аж ахуй нэгжийн орлогын албан татвар |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| БЗС | Боловсролын зээлийн сан |
| НББББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| НББОУС | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УЗ | Удирдах зөвлөл |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.23 № 06/774
танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОР Б.ОЧИРХУЯГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын их сургууль сургалтын үйл ажиллагаанд шинэ мэргэжлээр сургалт эрхлэх зөвшөөрлийг Боловсролын сайдын 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/250 дугаар тушаалаар Олон нийтийн харилцаа, мэдээлэл мэргэжлээр бакалавр, Хиймэл оюун ухаан мэргэжлээр бакалавр, магистр, Хүрээлэн буй орчны инженерчлэл мэргэжлээр магистрын түвшинд батлуулсан байна.

Тайлант онд дансны авлагын үлдэгдэл 3,411.9 сая төгрөгөөр өссөн нь боловсролын зээлийн сангаас 1418 суралцагчийн 9-12 дугаар сарын санхүүжилт дутуу орсонтой холбоотой байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 2025 оны 12 дугаар сард жилийн 19 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай нэг бүр нь 0.1 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй 13 мянган ширхэг, Бэрс бондыг 1,300.0 сая төгрөгөөр худалдан авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5 дах заалтын дагуу Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн Засаг, Хөгжлийн Сайдын 2025 оны А/69 дүгээр тушаалаар Монгол Улсын их сургуулийг эрдэм шинжилгээний байгууллагад хамруулж, 2025 оны А/72 дугаар тушаалаар судалгааны үндсэн чиглэлийг батлсны дагуу тус сургуулийн профессор багш, эрдэм шинжилгээний ажилтнууд шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг тендерт оролцохгүйгээр шууд гэрээлэн хэрэгжүүлэх боломжтой болсон байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2026\0316 SAG-54.Docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **38,393,120,736.16** | **33,192,301,811.83** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **28,653,692,408.01** | **18,002,191,710.53** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 15,919,593,866.69 | 11,674,836,376.29 |
| 31210 | Төгрөг | 11,695,444,039.99 | 10,343,688,017.48 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 11,695,444,039.99 | 10,343,688,017.48 |
| 31220 | Гадаад валют | 4,224,149,826.70 | 1,331,148,358.81 |
| 31223 | Арилжааны банк дахь харилцах | 4,224,149,826.70 | 1,331,148,358.81 |
| 31500 | Хадгаламж | 12,734,098,541.32 | 6,327,355,334.24 |
| **32** | **БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | **-** | **1,300,198,610.39** |
| 32100 | Үнэт цаас | - | 1,300,198,610.39 |
| 32110 | Төгрөг | - | 1,300,198,610.39 |
| **33** | **АВЛАГА** | **2,078,378,091.26** | **5,490,334,018.66** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 798,263,725.00 | 4,676,933,173.17 |
| 33402 | Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | 107,828,195.87 | 95,763,562.24 |
| 33500 | Бусад авлага | 1,172,286,170.39 | 717,637,283.25 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 1,164,893,394.64 | 637,928,752.69 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 7,392,775.75 | 79,708,530.56 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **1,625,433,741.37** | **1,771,920,910.08** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 816,342,034.73 | 1,344,401,626.86 |
| 34710 | Урьдчилгаа тооцоо | 809,091,706.64 | 427,519,283.22 |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 760,938,661.04 | 405,171,936.22 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 7,378,897.00 | 9,467,259.00 |
| 34714 | Томилолтын урьдчилгаа | 40,774,148.60 | 12,880,088.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6,035,616,495.52** | **6,627,656,562.17** |
| 35100 | Түүхий эд материал | 129,998,386.47 | 125,287,537.56 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 128,118,831.47 | 121,798,825.36 |
| 35130 | Эм боох материал | 1,879,555.00 | 3,488,712.20 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 15,316,906.00 | 14,397,754.34 |
| 35400 | Хангамжийн материал | 5,857,781,203.05 | 6,468,671,270.27 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 36,503,877.31 | 127,242,908.36 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,376,462,104.62 | 1,405,292,747.73 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 139,642,668.69 | 184,937,950.92 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 18,274,062.50 | 43,910,550.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 33,006,880.67 | 31,699,919.75 |
| 35460 | Хүнсний материал | 511,284.00 | 500,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,253,380,325.26 | 4,675,087,193.51 |
| 35600 | Мал амьтад | 32,520,000.00 | 19,300,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **107,086,600,567.42** | **114,023,491,928.36** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **107,086,600,567.42** | **114,023,491,928.36** |
| 39200 | Биет хөрөнгө | 97,033,204,623.06 | 103,546,309,417.65 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 85,185,387,512.55 | 86,687,789,229.53 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (14,309,929,049.32) | (16,543,794,343.22) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,315,583,843.00 | 1,293,528,287.45 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,088,656,457.64) | (1,137,827,789.35) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 41,593,629,793.76 | 45,599,362,373.51 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (28,735,116,028.25) | (32,463,186,154.06) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,581,644,589.11 | 10,137,944,988.81 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (6,525,949,489.68) | (7,065,685,971.20) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 188,034,230.85 | 188,034,230.85 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (127,767,112.02) | (129,845,431.23) |

| | | | |
|---|---|---|---|
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 17,940,850.00 | 17,940,850.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 637,518,592.04 | 632,923,393.80 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (365,054,375.44) | (393,243,114.77) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 4,290,170,986.59 | 10,623,912,228.59 |
| 39217 | Ном | 5,375,766,737.51 | 6,098,456,638.94 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 10,053,395,944.36 | 10,477,182,510.71 |
| 39301 | Програм хангамж | 3,240,816,289.21 | 3,278,677,306.05 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,465,158,059.26) | (1,902,298,299.91) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,277,737,714.41 | 9,100,803,504.57 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **145,479,721,303.58** | **147,215,793,740.19** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **17,787,008,060.15** | **20,647,753,159.66** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **17,787,008,060.15** | **20,647,753,159.66** |
| 41300 | Өглөг | 1,813,956,388.51 | 1,158,215,700.05 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 570,086.48 | 1,095,983.51 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 172,639,783.64 | 95,416,468.64 |
| 41360 | Бусад өглөг | 1,640,746,518.39 | 1,061,703,247.90 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,373,228,236.00 | 443,087,241.46 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 143,599,461.76 | 425,248,481.70 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 62,773,453.22 | 89,946,122.46 |
| 41364 | НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | 220,556.41 | 52,375,202.28 |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | 60,924,811.00 | 51,046,200.00 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 15,973,051,671.64 | 19,489,537,459.61 |
| 41420 | Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого | 9,906,203,366.81 | 13,831,735,116.14 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 6,066,848,304.83 | 5,657,802,343.47 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **127,692,713,243.43** | **126,568,040,580.53** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 127,692,713,243.43 | 126,568,040,580.53 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 33,648,469,662.01 | 33,648,469,662.01 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 33,648,469,662.01 | 33,648,469,662.01 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 64,063,730,501.19 | 62,939,057,838.29 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 76,558,695,091.07 | 64,063,730,501.19 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (12,494,964,589.88) | (1,124,672,662.90) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 29,980,513,080.23 | 29,980,513,080.23 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **145,479,721,303.58** | **147,215,793,740.19** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **84,091,812,378.93** | **107,015,141,976.26** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **81,670,937,980.53** | **107,015,141,976.26** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 81,516,588,983.43 | 104,597,351,205.78 |
| 1201 | Хүүгийн орлого | 2,527,668,804.12 | 1,820,394,598.76 |
| 120002 | Бусад хүүгийн орлого | 2,527,668,804.12 | 1,820,394,598.76 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 77,037,302,336.28 | 97,788,121,262.62 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,326,379,148.20 | 91,583,916,645.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,710,923,188.08 | 6,204,204,617.62 |
| 120005 | Түрээсийн орлого | 225,784,475.00 | 274,090,710.00 |
| 120009 | Бусад орлого | 97,472,756.03 | 33,021,095.95 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,628,360,612.00 | 4,681,723,538.45 |
| 122 | Тусламжийн орлого | 154,348,997.10 | 1,937,725,095.78 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 148,748,500.00 | 1,496,687,659.28 |
| 12211 | Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | | 905,297,830.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | | 905,297,830.00 |
| 122001 | Бусад хандив тусламж /дотоод/ | 148,748,500.00 | 591,389,829.28 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 5,600,497.10 | 441,037,436.50 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | 480,065,674.70 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | | 480,065,674.70 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,420,874,398.40** | |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,420,874,398.40 | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 1,854,878,718.40 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 565,995,680.00 | |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **96,398,466,520.67** | **108,021,062,227.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **96,398,466,520.67** | **108,021,062,227.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **95,245,398,945.25** | **106,861,278,434.71** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 53,938,133,651.55 | 62,640,266,150.11 |
| 210101 | Үндсэн цалин | 53,938,133,651.55 | 50,319,436,560.01 |
| 210102 | Нэмэгдэл | | 9,912,269,705.10 |
| 210104 | Урамшуулал | | 2,220,499,955.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 188,059,930.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,342,774,869.79 | 7,743,884,281.85 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 5,045,414,941.82 | 5,307,604,323.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 340,523,672.17 | 635,444,510.07 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 174,365,882.06 | 318,925,054.05 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 145,714,464.24 | 290,431,691.02 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 636,755,909.50 | 1,191,478,703.24 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,424,274,392.29 | 2,872,748,323.88 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 909,535,741.07 | 1,200,166,050.39 |
| 210302 | Түлш, халаалт | 1,033,382,972.13 | 1,178,019,604.52 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 460,819,839.09 | 491,874,668.97 |
| 210304 | Байрны түрээс | 20,535,840.00 | 2,688,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,924,888,530.32 | 2,117,513,234.79 |
| 210401 | Бичиг хэрэг | 169,797,657.85 | 204,251,252.02 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,439,229.00 | 55,257,755.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 219,822,554.10 | 213,465,485.42 |
| 210404 | Ном, хэвлэл | 50,369,214.70 | 66,550,479.33 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 69,690,704.00 | 58,738,985.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 126,558,131.55 | 180,521,465.39 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 726,367,317.33 | 789,707,785.25 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 170,505,275.21 | 127,832,778.25 |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | 355,338,446.58 | 421,187,248.73 |
| 2105 | Нормативт зардал | 5,137,375.00 | 9,459,918.11 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 734,210.00 | 7,515,814.11 |
| 210502 | Хоол, хүнс | 3,155,865.00 | 1,244,104.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,247,300.00 | 700,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 714,731,302.08 | 1,714,788,280.22 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,297,900.00 | 4,499,500.00 |
| 210602 | Тавилга | 1,111,200.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 649,353.00 | 1,375,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 710,672,849.08 | 1,708,913,780.22 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 629,272,133.50 | 588,829,839.67 |
| 210701 | Гадаад албан томилолт | 318,392,479.01 | 374,375,229.21 |
| 210702 | Дотоод албан томилолт | 157,443,661.33 | 134,052,205.46 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 153,435,993.16 | 80,402,405.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,982,471,129.56 | 2,004,722,517.64 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,726,843,668.20 | 1,501,688,777.32 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 54,205,110.00 | 56,821,280.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 8,222,460.00 | 2,768,996.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,777,216.00 | 4,182,693.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 360,000.00 | 73,660.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 162,876,856.46 | 356,183,164.11 |
| 210807 | Газрын төлбөр | 7,643,709.00 | 61,528,468.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 16,204,861.06 | 11,876,919.21 |
| 210810 | Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/ | 1,000,000.00 | 57,700.00 |
| 210812 | Санхүүгийн зардал /ТӨҮГ/ | - | 2,370,480.00 |
| 210813 | Бусад зардал /ТӨҮГ/ | 3,337,248.84 | 6,954,300.00 |
| 210814 | Орлогын татварын зардал /ТӨҮГ/ | - | 216,080.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,283,715,561.16 | 27,169,065,888.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,079,348,650.65 | 1,618,312,399.04 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,400,123,325.02 | 17,043,951,183.97 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 8,804,243,585.49 | 8,506,802,305.43 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,153,067,575.42** | **1,159,783,793.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,153,067,575.42 | 1,159,783,793.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,153,067,575.42 | 1,159,783,793.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(12,306,654,141.74)** | **(1,005,920,251.45)** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **132,605,391.44** | **346,797,700.98** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 132,421,391.17 | 317,457,062.84 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 184,000.27 | 29,340,638.14 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **320,915,839.58** | **465,550,112.43** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 79,493,963.72 | 272,291,277.97 |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 224,486,730.96 | 193,258,834.46 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 16,935,144.90 | |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **(188,310,448.14)** | **(118,752,411.45)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | **(12,494,964,589.88)** | **(1,124,672,662.90)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **87,836,123,923.28** | **100,322,953,977.77** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **84,116,582,755.10** | **100,322,953,977.77** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 84,012,572,255.10 | 98,438,663,427.77 |
| 1201 | Хүүгийн орлого | 2,870,391,578.17 | 1,887,324,740.81 |
| 120002 | Бусад хүүгийн орлого | 2,870,391,578.17 | 1,887,324,740.81 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 80,932,586,722.93 | 96,289,952,876.96 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 73,188,379,259.36 | 89,169,068,701.06 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,744,207,463.57 | 7,120,884,175.90 |
| 120005 | Түрээсийн орлого | 209,593,954.00 | 261,385,810.00 |
| 122 | Тусламжийн орлого | 104,010,500.00 | 1,670,818,830.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 104,010,500.00 | 1,670,818,830.00 |
| 12211 | Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | | 1,548,148,830.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | | 1,548,148,830.00 |
| 122001 | Бусад хандив тусламж /дотоод/ | 104,010,500.00 | 122,670,000.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | 213,471,720.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | | 213,471,720.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,719,541,168.18** | |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,719,541,168.18 | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 1,301,704,296.18 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,417,836,872.00 | |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **86,441,718,075.62** | **100,637,142,756.52** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **86,441,718,075.62** | **100,637,142,756.52** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **85,261,054,997.20** | **99,456,788,433.52** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 54,066,164,367.70 | 62,281,091,584.86 |
| 210101 | Үндсэн цалин | 54,066,164,367.70 | 56,103,569,907.04 |
| 210102 | Нэмэгдэл | | 4,311,177,883.86 |
| 210104 | Урамшуулал | | 1,427,447,882.05 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 438,895,911.91 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,364,048,323.54 | 7,698,691,594.31 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 5,588,939,219.13 | 5,532,568,012.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 366,920,812.25 | 722,501,994.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 70,412,842.93 | 262,227,423.85 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 64,905,741.08 | 229,407,400.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 272,869,708.15 | 951,986,763.56 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,063,039,101.69 | 3,379,752,154.73 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 913,266,533.62 | 1,189,128,689.25 |
| 210302 | Түлш, халаалт | 683,568,340.29 | 1,691,421,548.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 464,028,227.78 | 496,513,917.38 |
| 210304 | Байрны түрээс | 2,176,000.00 | 2,688,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,793,711,667.82 | 1,805,963,018.75 |
| 210401 | Бичиг хэрэг | 70,982,452.00 | 83,389,585.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,539,189.00 | 35,281,843.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 234,924,654.10 | 211,240,415.42 |
| 210404 | Ном, хэвлэл | 262,310,134.59 | 198,106,230.79 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 68,364,064.00 | 62,161,485.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 520,049,712.11 | 418,317,580.79 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 605,541,462.02 | 797,465,878.35 |

| | | | |
|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 5,842,899.00 | 7,123,887.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 866,710.00 | 1,300,987.00 |
| 210502 | Хоол, хүнс | 448,974.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,527,215.00 | 5,822,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,069,740,346.00 | 1,916,311,841.20 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 47,437,200.00 | 45,665,100.00 |
| 210602 | Тавилга | 43,907,186.00 | 19,930,035.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,768,250.00 | 2,914,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 971,627,710.00 | 1,847,802,206.20 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 561,658,613.87 | 547,468,823.07 |
| 210701 | Гадаад албан томилолт | 387,922,677.54 | 397,287,608.11 |
| 210702 | Дотоод албан томилолт | 150,723,678.33 | 123,948,332.96 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 23,012,258.00 | 26,232,882.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,030,177,474.10 | 2,076,294,558.12 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,674,049,385.48 | 1,570,896,992.74 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 57,000,000.00 | 56,821,280.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 8,491,560.00 | 2,768,996.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,662,163.00 | 4,780,521.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 720,000.00 | 472,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 181,574,666.46 | 346,288,443.33 |
| 210807 | Газрын төлбөр | 9,948,709.00 | 60,680,588.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 96,730,990.16 | 33,585,237.05 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,306,672,203.48 | 19,744,090,971.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 640,422,015.34 | 623,013,566.56 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,666,250,188.14 | 19,121,077,404.92 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,180,663,078.42 | 1,180,354,323.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,180,663,078.42 | 1,180,354,323.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 938,749,050.42 | 820,880,923.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 241,914,028.00 | 359,473,400.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **1,394,405,847.66** | **(314,188,778.75)** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **9,936,521,863.68** | **10,451,563,857.59** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,936,521,863.68** | **10,451,563,857.59** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 9,936,521,863.68 | 10,451,563,857.59 |
| 220001 | Барилга байгууламж | | 6,452,974,577.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 1,951,670,436.20 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 746,720,234.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,936,521,863.68 | |
| 225103 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | | 1,300,198,610.39 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(9,936,521,863.68)** | **(10,451,563,857.59)** |
| 14 | Бусад эх үүсвэр | | 122,071,529.15 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | | 122,071,529.15 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 92,065,339.79 | 7,819,590.29 |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 92,065,339.79 | 7,819,590.29 |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **(92,065,339.79)** | **114,251,938.86** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **(8,634,181,355.81)** | **(10,651,500,697.48)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 37,287,873,763.82 | 28,653,692,408.01 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 28,653,692,408.01 | 18,002,191,710.53 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **33,648,469,662.01** | **29,980,513,080.23** | **76,521,129,051.07** | **140,150,111,793.31** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 37,566,040.00 | 37,566,040.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 33,648,469,662.01 | 29,980,513,080.23 | 76,558,695,091.07 | 140,187,677,833.31 |
| Тайлант үеийн үр дүн | | | (12,494,964,589.88) | (12,494,964,589.88) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **33,648,469,662.01** | **29,980,513,080.23** | **64,063,730,501.19** | **127,692,713,243.43** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 33,648,469,662.01 | 29,980,513,080.23 | 64,063,730,501.19 | 127,692,713,243.43 |
| Тайлант үеийн үр дүн | | | (1,124,672,662.90) | (1,124,672,662.90) |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **33,648,469,662.01** | **29,980,513,080.23** | **62,939,057,838.29** | **126,568,040,580.53** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2024 оны төсвийн гүйцэтгэл | 2025 оны | | Зөрүү | Хувиар |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **НИЙТ ОРЛОГО** | **87,836,123,923.28** | **101,608,263,580.00** | **100,322,953,977.68** | **981,152,449.44** | 98.7 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС** | **3,719,541,168.18** | **7,654,280,540.00** | **1,761,620,550.00** | **5,892,659,990.00** | 23.0 |
| **Улсын төсвийн санхүүжилт** | **3,240,361,488.18** | **7,294,232,540.00** | **1,548,148,830.00** | **5,746,083,710.00** | 21.2 |
| Судалгаа, гэрээт ажил, төслийн санхүүжилт | 1,281,222,800.00 | 817,207,000.00 | - | 817,207,000.00 | |
| Үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний санхүүжилт | 126,921,080.00 | 119,853,000.00 | 905,297,830.00 | (785,444,830.00) | 755.3 |
| ЗГ-ын гэрээгээр суралцагчдын санхүүжилт | 530,513,312.00 | 1,917,088,000.00 | 642,851,000.00 | 1,274,237,000.00 | 33.5 |
| Тогтмол зардлын санхүүжилт | 1,301,704,296.18 | 4,440,084,540.00 | - | 4,440,084,540.00 | |
| **Тусгай зориулалтын шилжүүлэг** | **479,179,680.00** | **360,048,000.00** | **213,471,720.00** | **146,576,280.00** | 59.3 |
| **БАЙГУУЛЛАГЫН ӨҮАО-ООС** | **84,116,582,755.10** | **92,393,983,040.00** | **98,561,333,427.68** | **(6,348,837,540.56)** | 106.9 |
| **Үндсэн үйл ажиллагааны орлого** | **73,439,400,887.36** | **83,796,631,690.00** | **89,169,068,701.06** | **(5,370,437,011.06)** | 106.4 |
| Судалгааны орлого | 8,597,733,187.16 | 7,069,120,020.00 | 10,556,082,356.44 | (3,486,962,336.44) | 149.3 |
| Сургалтын орлого | 64,841,667,700.20 | 76,727,511,670.00 | 78,612,986,344.62 | (1,883,474,674.62) | 102.5 |
| **Туслах үйл ажиллагааны орлого** | **10,573,171,367.74** | **8,597,351,350.00** | **9,269,594,726.62** | **(978,400,529.50)** | 111.4 |
| Мэргэжлийн үйлчилгээний | 1,381,647,821.05 | 1,652,448,130.00 | 1,964,425,214.17 | (311,977,084.17) | 118.9 |
| Тусгай үйлчилгээний | 2,657,691,802.43 | 2,811,909,110.00 | 3,290,780,369.25 | (478,871,259.25) | 117.0 |
| **Бусад** | **6,533,831,744.26** | **4,132,994,110.00** | **4,014,389,143.20** | **(187,552,186.08)** | 104.5 |
| **ТУСЛАМЖИЙН ОРЛОГО** | **104,010,500.00** | **1,560,000,000.00** | **122,670,000.00** | **1,437,330,000.00** | 7.9 |
| Дотоод хандив | 104,010,500.00 | 1,560,000,000.00 | 122,670,000.00 | 1,437,330,000.00 | 7.9 |
| **НИЙТ ЗАРДАЛ** | **96,470,305,279.12** | **119,911,364,695.15** | **111,088,706,614.11** | **8,632,752,867.11** | 92.8 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **86,689,509,113.41** | **105,645,675,235.15** | **100,637,142,756.52** | **4,818,428,654.31** | 95.4 |
| Цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулал | 54,066,164,367.70 | 63,348,706,366.00 | 62,281,091,584.86 | 1,067,614,781.14 | 98.3 |
| Ажил олгогчийн нийгмийн даатгалын төлөх шимтгэл | 6,364,048,323.54 | 7,979,603,226.15 | 7,698,691,594.31 | 280,911,631.84 | 96.5 |
| Байр ашиглалттай холбоотой зардал | 2,060,863,101.69 | 4,440,084,544.00 | 3,379,752,154.73 | 1,063,020,389.27 | 76.1 |
| Хангамж бараа материалын зардал | 1,798,456,067.82 | 2,401,569,399.00 | 1,805,963,018.75 | 595,606,380.25 | 75.2 |
| Нормативт зардал | 5,842,899.00 | 26,707,900.00 | 7,123,887.00 | 19,584,013.00 | 26.7 |
| Эд хогшил, урсгал засвар зардал | 1,069,740,346.00 | 2,346,054,530.00 | 1,916,311,841.20 | 429,742,688.80 | 81.7 |
| Томилолт, зочны зардал | 561,658,613.87 | 914,244,480.00 | 547,468,823.07 | 366,775,656.93 | 59.9 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,085,204,851.83 | 3,032,386,090.00 | 2,076,294,558.12 | 755,019,557.56 | 75.1 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 679,635,977.40 | 895,616,190.00 | 623,013,566.56 | 278,882,773.44 | 68.9 |
| Сургалтын үйлчилгээний зардал | 4,498,135,868.94 | 5,484,682,730.00 | 4,139,594,200.53 | 1,345,088,529.47 | 75.5 |
| Оюутны үйлчилгээний зардал | 957,114,519.05 | 991,300,660.00 | 1,418,780,297.39 | (427,479,637.39) | 143.1 |
| Эрдэм шинжилгээ, судалгаа, | 2,895,340,610.22 | 8,151,091,550.00 | 2,924,497,151.80 | 5,226,594,398.20 | 35.9 |
| Төсөл, гэрээт ажилтай холбоотой зардлууд | 8,466,640,487.93 | 4,019,953,670.00 | 10,638,205,755.20 | (6,618,252,085.20) | 264.6 |
| Бусад урсгал шилжүүлэг | 1,180,663,078.42 | 1,613,673,900.00 | 1,180,354,323.00 | 435,319,577.00 | 73.0 |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,780,796,165.71** | **14,265,689,460.00** | **10,451,563,857.59** | **3,814,324,212.80** | 73.3 |
| Барилга байгууламж | 6,770,647,921.73 | 13,416,191,720.00 | 8,404,645,013.20 | 5,011,546,706.80 | 62.6 |
| Бусад хөрөнгө | 3,010,148,243.98 | 849,497,740.00 | 746,720,234.00 | 102,777,506.00 | 87.9 |
| Стратегийн нөөц хөрөнгө | | | 1,300,198,610.39 | (1,300,000,000.00) | |
| **Гадаад валютын олз, гарзын зөрүү** | | | **114,251,938.95** | | |
| **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | **37,287,873,763.82** | **28,653,692,408.01** | **28,653,692,408.01** | | |
| **МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **28,653,692,408.01** | **10,350,591,292.86** | **18,002,191,710.53** | **(7,651,600,417.67)** | |
| Нийт ажиллагсдын тоо | 1,571 | 1,560 | 1,490 | 70 | 95.5 |
| Удирдах ажилтан | 42 | 49 | 48 | 1 | 97.9 |
| Багшийн орон тоо | 854 | 846 | 802 | 44 | 94.7 |
| Гүйцэтгэх ажилтан | 419 | 448 | 430 | 18 | 95.9 |
| Үйлчлэх ажилтан | 256 | 217 | 210 | 7 | 96.7 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын их сургууль нь алсын хараагаа "Дэлхийн түвшний их сургууль болоход оршино. Үүний дүнд 2025 онд чөлөөт мэдлэг буюу либерал арт уламжлалд суурилсан, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх байр суурьтай судалгааны их сургууль болж, улмаар Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаж орно" гэж тодорхойлсон байна.

Дээрх алсын харааны хүрээнд "Шинжлэх ухааны үндсэн салбаруудыг хамарсан чөлөөт мэдлэг буюу "либерал арт" уламжлалд суурилсан хөтөлбөртэй, байгалийн ухаан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь асуудлаар сургалт, судалгааны ажлыг тогтвортой эрхэлж, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой академик буюу эрдмийн байгууллага болно" гэсэн эрхэм зорилго тавин ажиллаж байна.

Тайлант онд "THE" олон улсын үнэлгээний байгууллагаар үнэлүүлж, 2025 оны олон улсын үнэлгээний аргачлалд дурдсан шалгууруудыг хангаж чансаагаараа дэлхийд (1501+)-д эрэмбэлэгдсэн байна.

Удирдах зөвлөлийн 2024 оны 13 дугаар тогтоолоор бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотой сургуулийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- Шинжлэх ухаан, технологийн ололт, сургалтын нийтлэг шаардлага, нийгмийн эрэлтэд тулгуурласан бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхэлж, мэргэжлийн болон иргэний өндөр боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, чадавхжуулах;
- Шинжлэх ухааны судалгаа хийх, шинэ мэдлэг бүтээж сургалт, судалгаанд нэвтрүүлэх, инновацын бодлого хэрэгжүүлэх;
- Нийгэмд эрдэм мэдлэг түгээх, соён гэгээрүүлэх, Монгол Улсын хөгжил дэвшилд чиглэсэн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардлагатай шинжлэх ухааны үндэслэлтэй санал зөвлөмж боловсруулж дэвшүүлэх;
- Монголын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, үндэсний хэл, соёл, түүхийн дархлааг бэхжүүлэх хүрээнд монгол судлалыг хөгжүүлэх;
- Багш, ажилтан, суралцагчдын ажиллах, суралцах хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, эрхийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого хэрэгжүүлэх;

Тус сургууль нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Дээд боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх комиссын 2024 оны 29 дүгээр тогтоолоор 10 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдэж, гэрчилгээгээ авч, 2024-2025 оны хичээлийн жилд 815 үндсэн багш, 34 удирдах ажилтан, 455 гүйцэтгэх ажилтан, 219 үйлчилгээний ажилтан нийт 1523 багш, ажилтантайгаар үйл ажиллагаа явуулсан байна.

Тус сургуулийн дүрэмд зааснаар өмчийг 100 хувь төр эзэмшиж байгаа бөгөөд төрийн өмчийн төлөөллийг Засгийн газраас эрх олгосноор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлэхээр заасан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын их сургуулийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1940 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 45 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн

этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах" гэсэн заалттай нийцэж байна.

Сургуулийн удирдлагыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яам, агентлагтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө" гэж заасны дагуу Боловсролын сайд томилсон байна.

Тус сургууль нь үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын багц хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд сургуулийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2024 оны 12 сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон, 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс дагаж мөрдсөн;
- Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 2025 оны 6 дугаар сарын 15-наас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. "Дээд сургууль" гэсэн ангиллыг олон улсын жишигт нийцүүлэн хүчингүй болгож, их сургууль, коллеж, судалгааны их сургууль гэсэн шинэ ангилалд шилжүүлсэн;
- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор "Дээд боловсролын байгууллагын суралцагчдад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэх журам"-ыг шинэчлэн баталсан;
- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоолоор 2026 оныг "Боловсролыг дэмжих жил" болгон зарласан;
- Боловсролын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам шинэчлэн баталсан;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн батлах тухай тушаал.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Монгол Улсын их сургуулийн удирдах зөвлөл тайлант онд 4 удаа хуралдаж, санхүү бүртгэл болон үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө оруулалт худалдан авалтын төлөвлөгөөний биелэлт, үүссэн тулгамдсан нөхцөл байдлыг шийдвэрлэхээр 16 асуудал хэлэлцэж, 30 тогтоолыг баталсан байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, захирлын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/48 дугаар тушаалаар баталж, мөрдөж байна.

Одоогийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монгол Улсын их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,736.1 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 28,653,692.4 | 18,002,191.7 | (10,651,500.7) |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | | 1,300,198.6 | 1,300,198.6 |
| Авлага | 2,078,378.1 | 5,490,334.0 | 3,411,955.9 |
| Урьдчилгаа | 1,625,433.7 | 1,771,920.9 | 146,487.2 |
| Бараа материал | 6,035,616.5 | 6,627,656.6 | 592,040.1 |
| Үндсэн хөрөнгө | 107,086,600.6 | 114,023,491.9 | 6,936,891.4 |
| **Нийт хөрөнгө** | **145,479,721.3** | **147,215,793.7** | **1,736,072.4** |
| Өр төлбөр | 17,787,008.1 | 20,647,753.2 | 2,860,745.1 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 127,692,713.2 | 126,568,040.6 | (1,124,672.7) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **145,479,721.3** | **147,215,793.7** | **1,736,072.4** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 18,002.2 сая төгрөг болж 10,651.5 сая төгрөгөөр буурсан нь томоохон хөрөнгө оруулалтын төсөл болох хичээлийн 3Б байрны санхүүжилтэд 6,333.7 сая төгрөг, ШУТУПаркийн барилгын их засварт 120.0 сая төгрөг тус тус зарцуулсантай холбоотой байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 1,300.9 сая төгрөг болсон нь хүүгийн орлого нэмэгдүүлэх зорилгоор мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийн тодорхой хэсгийг үнэт цаас (бонд)-д хөрөнгө оруулсантай холбоотой байна.

Дансны авлагын үлдэгдэл 5,490.3 сая төгрөг болж 3,411.9 сая төгрөгөөр өссөн нь боловсролын зээлийн сангаас 9-12 сарын санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 6,627.6 сая төгрөг болж 592.0 сая төгрөгөөр өссөн нь 3,706.5 сая төгрөгийн бараа материалын худалдан авч, хандив тусламжаар 111.4 сая төгрөг, бусад эх үүсвэрээр 10.7 сая төгрөг, нийт 3,896.4 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 3,109.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 68.2 сая төгрөгийн барааг дотоод тооцоогоор шилжүүлэн, ТӨБЗГ-ын 2025 оны 452 дугаар тогтоол, МУИС-ийн захирлын 2025 оны А/456 дугаар тушаалын дагуу 126.7 сая төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 114,023.5 сая төгрөг болж, 6,936.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Тайлант хугацаанд 10,236.8 сая төгрөгийн хөрөнгө өөрийн хөрөнгөөр худалдаж авч, 5,334.7 сая төгрөгийн хөрөнгө хандив тусламжаар хүлээн авсан,
- ТӨБЗГ-ын 2025 оны 452 399 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн 1,761.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан, тайлант үед 8,506.8 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон.

Барилга байгууламжийн дансанд 791.7 сая төгрөгийн 3 ширхэг орон сууцны байр, 532.6 сая төгрөгийн 298.27 м.кв талбай бүхий орон сууцны 6 байр, 2 авто зогсоол, Төв аймгийн Эрдэнэ суманд нарны эрчим хүчээр ажиллах лабораторийн 109.9 сая төгрөгийн барилга, ШУТУБП-д 6.0 сая төгрөгийн нөөцийн сав болон 393.9 сая төгрөгийн их засварын ажил, нийт 1,834.1 сая төгрөгийн хөрөнгө нэмж бүртгэсэн байна.

Дуусаагүй барилга дансанд хичээлийн 3 дугаар байрны барилгын ажлын 6,333.7 сая төгрөгийн зардлыг хуримтлуулан бүртгэсэн.

Тоног төхөөрөмжийн дансанд худалдан авсан 2,486.2 сая төгрөгийн хөрөнгө, хандив тусламжаар ирсэн 2,595.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, 2025 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитын зөвлөмжийн дагуу Шинжлэх ухаан боловсролын сургууль нь 450.7 сая төгрөгийн хөрөнгийн нэршил болон ангиллыг залруулж бүртгэж, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн дагуу Эрдэм шинжилгээ, инновацын нэгж 7.4 сая төгрөгийн хөрөнгийг залруулан бүртгэлд тусгасан.

Тайлант онд 786.8 сая төгрөгийн тавилга эд хогшил, 186.0 сая төгрөгийн ном, 4.9 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг худалдан авч, хандив тусламжаар 38.5 сая төгрөгийн тавилга эд хогшил, 549.4 сая төгрөгийг ном, 0.3 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг тус тус хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 10,477.1 сая төгрөг болж, 423.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2024 оны А/133, А/126 дугаар тушаалаар батлагдсан 'Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийх журам', Үл хөдлөхийн үнэлгээ хийх аргачлалыг үндэслэн захирлын 2025 оны А/153 дугаар тушаалаар 11 ширхэг 823.1 сая төгрөгийн газар бүртгэсэнтэй холбоотой байна.

Дансны өглөгийн үлдэгдэл 1,158.2 сая төгрөг болж 655.7 сая төгрөгөөр буурсан нь бараа болон хөрөнгө худалдан авахтай холбоотойгоор харилцагч байгууллагад төлөх төлбөрийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Урьдчилж орсон орлого 19,489.5 сая төгрөг болж 3,516.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны урьдчилж орсон сургалтын төлбөрийн орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн данс 62,939.1 сая төгрөг болж 1,124.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд алдагдалтай ажилласнаас шалтгаалсан байна.

### 3.5 Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу их сургууль нь байгууллагын үйлдвэрлэл, бизнес төлөвлөгөөнд эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, ТӨБЗГ-ын тогтоолоор зөвшөөрсөн үндсэн хөрөнгө болон засварын зардал зэргийг төрөлжүүлэн төлөвлөж, Удирдах зөвлөлөөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монгол Улсын Их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 28 дугаар тогтоолоор 2025 оны орлого, зардлын төсвийг баталсан ба тайлант онд 1 удаа төсвийн тодотгол хийгдэж, 2025 оны 14 дүгээр тогтоолоор орлогыг 130,261.9 сая төгрөгөөр, зардлыг 119,911.4 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 14,265.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 100,637.1 сая төгрөгийн орлого олж, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 10,451.5 сая төгрөгийн бүрдүүлж, 111,088.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Монгол Улсын Их сургуулийн үйл ажиллагааны нийт орлого 100,322.9 сая төгрөг болж, өмнөх оны 87,836.1 сая төгрөгтэй харьцуулахад 12,486.8 сая төгрөгөөр буюу 14.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Энэхүү өсөлтөд Монгол Улсын Их сургуулийн Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу 2024–2025 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийг 15.4 хувь, 2025–2026 оны хичээлийн жилд 9.3 хувиар тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн болно.

Улсын төвлөрсөн төсвөөс олгосон санхүүжилт 1,385.4 сая төгрөг болж өмнөх оноос 1,035.5 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Засгийн газрын 2024 оны 164 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу улсын төсвийн санхүүжилт 2024 онд орж ирсэн боловч тайлант онд санхүүжилт орж ирээгүй нь буурахад гол нөлөө үзүүлсэн.

Нийт зардлын гүйцэтгэл нийт зардал 111,088.7 сая төгрөг болж, өмнөх оны 96,470.3 сая төгрөгтэй харьцуулахад 14,618.4 сая төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна. Нийт зардлын дийлэнх хэсгийг бараа, ажил үйлчилгээний зардал бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь 100,637.1 сая төгрөг болж өмнөх оноос 13,947.6 сая төгрөгөөр өссөн байна.

Зардлын бүтцэд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал нийт зардлын 63.0 хувийг эзэлж байгаа бөгөөд 69,979.7 сая төгрөг болж, өмнөх оноос 9,549.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь МУИС-ийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр багш, ажилтнуудын үндсэн цалинг 2024 оны 09 сарын 01 өдрөөс 30 хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор өссөн. Мөн эд хогшил, урсгал засварын зардал, байр ашиглалттай холбоотой зардал болон хангамж, бараа материалын зардал тодорхой хэмжээгээр өссөн байна.

Үйл ажиллагааны үр дүнг авч үзвэл 2025 онд 1,005.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь өмнөх оны 12,306.6 сая төгрөгийн алдагдалтай харьцуулахад буурсан

үзүүлэлттэй байна. Мөн үйл ажиллагааны бус орлого 346.8 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардал 465.5 сая төгрөг байгаа нь нийт дүнгээр 1,124.6 сая төгрөгийн алдагдал үүсэхэд нөлөөлсөн байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Монгол Улсын их сургууль , түүний гадаад, дотоод орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Мэдээлэл-Аудит ХХК-ийн ахлах аудитор Ц.Отгонжаргал, ахлах аудитор Д.Туяа, аудитор Н.Пүрэвсүрэн, аудитор Н.Ганданбаавар, аудитор С.Адьяахүү, хуулийн зөвлөх Б.Отгонтуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа, захирал Д.Товуудорж нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Оюунтөгөлдөр, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Монгол Улсын их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 4/473 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газар болон Мэдээлэл-Аудит ХХК-д ирүүлсэн.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 96,719.4 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож, 967.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сургууль төлөвлөгөө гаргаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2025 онд байр ашиглалтай холбоотой зардлаас 1,063.0 сая төгрөг, цалингийн зардлаас 1,067.6 сая төгрөг, томилолт зочны зардлаас 366.7 сая төгрөгийн зардлуудыг хэмнэж ажилласан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 810.9 сая төгрөгийн зөрчлөөс 80.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 730.9 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт 1. Мэдээлбэл зохих 2,697 гүйлгээнээс 261.1 сая төгрөгийн 33 гүйлгээг мэдээлээгүй, 469.8 сая төгрөгийн 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн үнэн зөв, иж бүрэн мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1. МУИС-ийн эрдэм шинжилгээний инновацын нэгж, бүрэлдэхүүн 17 сургуульд олон улсын санхүүжилттэй 197 төсөл, дотоодын санхүүжилттэй 64 төсөл хэрэгжиж байгаа боловч төслийн RPMS программд төслүүдийг нэгтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад, дотоодын санхүүжилттэй төслүүдийг RPMS программд нэгтгэхгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 80.0 сая төгрөгийн олон улсын онлайн сургалт худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт хийж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 1,911.1 сая төгрөгийн 23 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгснийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1,788.4 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг арилгасан байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/197 дугаар ректорын тушаалаар баталж, ҮАГ-ын www.fas.audit.mn системд ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 4/2175 дугаар албан бичгээр ирүүлснийг үнэлж үзэхэд 2.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, хариуцлага тооцох 2,689.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг арилгах 760.6 сая төгрөгийн 9 албан шаардлага, 77.7 сая төгрөгийн 6 зөвлөмж өгснийг хянахад хэрэгжилт 93.3 хувийн биелэлттэй байна

*Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитаар өгсөн | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 2,662.9 | 2 | 2,662.90 | 100.0 |
| Хариуцлага тооцох албан шаардлага | 1 | 2,689,445.2 | 1 | 1,958,532.80 | 72.8 |
| Албан шаардлага | 9 | 760,559.2 | 9 | 760,559.20 | 100.0 |
| Зөвлөмж | 6 | 77,696.2 | 6 | 77,696.20 | 100.0 |
| **Нийт дүн** | **18** | **3,530,363.5** | **18** | **2,799,451.10** | **93.3** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, тодруулгуудын хамт бэлтгэж байгаа эсэхийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,519.5 сая төгрөгийн 2 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Хаан банкны 2025 оны 8 дугаар сарын орлогын гүйлгээг ерөнхий журналтай тулгахад 1,426.5 сая төгрөгийн гүйлгээг бөөн дүнгээр бүртгэсэн;
- Тайлант онд 52 суралцагчид олгосон тэтгэлэг 92.9 сая төгрөгийн зардлыг бөөн дүнгээр бүртгэсэн зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 578.1 сая төгрөгийн зөрчил илэрсний 1.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 193.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 383.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 578.1 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 967.2 сая төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1. Баянхонгор аймагт ажилласан албан тушаалтанд томилолтын зардлыг 0.4 сая төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан журмын 1. “Төрийн албан хаагчийн дотоод албан томилолтын байрны зардлыг суманд 60,000 төгрөг, аймгийн төвд 130,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад 150,000 төгрөг” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий ажилтанд илүү олгосон 0.4 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2. Ховд, Баянхонгор аймгуудад албан томилолтоор ажиллахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалтыг зөрчиж байгууллагын томилолтын төсвөөс 0.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7 "Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалтыг зөрчиж байгууллагын томилолтын төсвөөс 0.8 сая төгрөг зарцуулсан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Тус сургуульд ажиллаж байсан 4 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 154.5 сая төгрөг байгууллагаас төлсөн боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 103.2 “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Шүүхийн шийдвэрээр тус сургуульд ажиллаж байсан ажилтнуудын ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

<u>Илрүүлэлт 2</u>. Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн урсгал засварын тендерийн ерөнхий өгөгдлийн шаардлагад ажилласан жилийн туршлага 1 жил болон түүнээс дээш жил байх, тусгай зөвшөөрөлтэй байх гэсэн шаардлагуудыг хангаагүй байгууллагыг сонгон шалгаруулж 38.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана”, “Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт”-ийн 18.1 "Ажиллах хүчний нөөц шаардана-Тухайн албан тушаалд ажилласан жилийн туршлага 1 жил ба түүнээс дээш байх", 18.3 "Тусгай зөвшөөрөл шаардана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Өглөг данстай холбоотой асуудал**

<u>Илрүүлэлт 1.</u> НДШ-ийн баталгаажсан тайлангийн дүнгээс санхүүгийн байдлын тайлан дахь НДШ-ийн өглөгийг 21.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална. 5.1.4. үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u> Санхүүгийн тайланг бэлтгэхдээ татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай тулгаж, үлдэгдлийг баталгаажуулж байх.

**Урьдчилж орсон орлого данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт 1. Санхүүгийн байдлын тайлан дахь урьдчилж орсон орлогын үлдэгдэл дүнгээс Сургалтын SISI программын дүн 314.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.4 "Үнэн зөв байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн байдлын тайлан дахь урьдчилж орсон орлогын үлдэгдэл дүнг сургалтын SISI программын дүнгээс зөрүүтэй байгааг арилгах.

**Зардал данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт 1. Багш дэмжих зардлаас багш ажилчдын эмчилгээний зардал, эм, витаминд 47.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 "Жил тутам холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдах", Захирлын 2020 оны А/13 дугаар тушаалаар баталсан "МУИС-ийн багш ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журам"-ын 3.3.5 "Эрүүл мэндийн болон урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах, рашаан сувиллаар үйлчлүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хаан банкны 2025 оны 8 дугаар сарын орлогын гүйлгээг ерөнхий журналтай тулгахад 1,426.5 сая төгрөгийн гүйлгээг бөөн дүнгээр бүртгэсэн. | 1 | 1,426,575.0 | | | 1 | 1,426,575.0 | 1 | 1,426,575.0 | | | | |
| 2 | Тайлант онд 52 суралцагчид олгогдсон тэтгэлэг 92.9 сая төгрөгийн зардлыг бөөн дүнгээр бүртгэсэн. | 1 | 92,924.0 | | | 1 | 92,924.0 | 1 | 92,924.0 | | | | |
| | **Дүн** | **2** | **1,519,499.0** | | | **2** | **1,519,499.0** | **2** | **1,519,499.0** | | | | |

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Тус сургуульд ажиллаж байсан 4 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 154.5 сая төгрөг байгууллагаас төлсөн боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна | 1 | 154,526.0 | | | 1 | 154,526.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | НДШ-ийн баталгаажсан тайлангийн дүнгээс Санхүүгийн байдлын тайлан дахь НДШ-ийн өглөгийг 21.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан. | 1 | 21,807.4 | | | | | 1 | 21,807.4 | | | | |
| 3 | Баянхонгор аймагт ажилласан албан тушаалтанд томилолтын зардлыг 0.4 сая төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна. | 1 | 374.0 | 1 | 374.0 | | | | | | | | |
| 4 | Ховд, Баянхонгор аймгуудад албан томилолтоор ажиллахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалтыг зөрчиж байгууллагын томилолтын төсвөөс 0.8 сая төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 817.9 | 1 | 817.9 | | | | | | | | |
| 5 | Багш дэмжих зардлаас багш ажилчдын эмчилгээний зардал, эм, витаминд 47.7 сая төгрөгийг зарцуулсан. | 1 | 47,712.4 | | | | | 1 | 47,712.4 | | | | |
| 6 | Санхүүгийн байдлын тайлангийн урьдчилж орсон орлогын үлдэгдэл дүнгээс Сургалтын SISI программын дүн 314.3 сая төгрөгөөр зөрүүтэй. | 1 | 314,356.8 | | | | | 1 | 314,356.8 | | | | |
| 7 | Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн урсгал засварын тендерийн ерөнхий өгөгдлийн шаардлагад ажилласан жилийн туршлага 1 жил болон түүнээс дээш жил байх, тусгай зөвшөөрөлтэй байх гэсэн шаардлагуудыг хангаагүй байгууллагыг сонгон шалгаруулж 38.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. | 1 | 38,518.6 | | | 1 | 38,518.6 | | | | | | |
| | **Дүн** | **7** | **578,113.1** | **2** | **1,191.9** | **2** | **193,044.6** | **3** | **383,876.6** | | | | |

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**
/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 2,697 гүйлгээнээс 261.1 сая төгрөгийн 33 гүйлгээг мэдээлээгүй, 469.8 сая төгрөгийн 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна | 1 | 730,912.4 | | | 1 | 730,912.4 |
| | **Дүн** | **1** | **730,912.4** | | | **1** | **730,912.4** |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| 1 | МУИС-ийн эрдэм шинжилгээний инновацын нэгж, бүрэлдэхүүн 17 сургуульд олон улсын санхүүжилттэй 197 төсөл, дотоодын санхүүжилттэй 64 төсөл хэрэгжиж байгаа боловч төслийн RPMS программд төслүүдийг нэгтгээгүй байна | 1 | | 1 | | | |
| 2 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 80.0 сая төгрөгийн олон улсын онлайн сургалт худалдан авсан байна. | 1 | 80,000.0 | 1 | 80,000.0 | | |
| | **Дүн** | **2** | 80,000.0 | **2** | **80,000.0** | | |
| | **Нийт дүн** | **3** | **810,912.4** | **2** | **80,000.0** | **1** | **730,912.4** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 173/A0150458 Улаанбаатар хот

САГ-2026/47/НА-СТА-ТОҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймагт ажилласан албан тушаалтанд томилолтын зардлыг 374,000.00 /гурван зуун далан дөрвөн мянган/ төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" тушаалаар батлагдсан журмын 1. "Төрийн албан хаагчийн дотоод албан томилолтын байрны зардлыг суманд 60,000 төгрөг, аймгийн төвд 130,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад 150,000 төгрөг" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий ажилтанд илүү олгосон 374,000.00 /гурван зуун далан дөрвөн мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Их Сургуулийн ректор /Б.Очирхуяг/, Санхүү бүртгэлийн газрын дарга /Н.Халиун/ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ

МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.ТОВУУДОРЖ

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

**АКТ**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 174/А0150458 Улаанбаатар хот

САГ-2026/47/ИА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ховд, Баянхонгор аймгуудад албан томилолтоор ажиллахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалтыг зөрчиж байгууллагын томилолтын төсвөөс 817,900.00 /найман зуун арван долоон мянга есөн зуун/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7 "Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн"-д үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалтыг зөрчиж байгууллагын томилолтын төсвөөс 817,900.00 /найман зуун арван долоон мянга есөн зуун/ төгрөг зарцуулсан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Их Сургуулийн ректор /Б.Очирхуяг/, Санхүү бүртгэлийн газрын дарга /Н.Халиун/ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ

МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.ТОВУУДОРЖ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 815/А0150458 Улаанбаатар хот

САГ-2026/47/ИА-СТА-ТӨУГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуульд ажиллаж байсан 4 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 154,526,026.62 /нэг зуун тавин дөрвөн сая таван зуун хорин зургаан мянга хорин зургаан төгрөг жаран хоёр мөнгө/ төгрөг байгууллагаас төлсөн боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шүүхийн шийдвэрээр тус сургуульд ажиллаж байсан ажилтнуудын ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын яамны салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга /Л.Төгсбаяр/-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.ТОВУУДОРЖ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр     Дугаар 816/А0150458     Улаанбаатар хот

САГ -2026/47/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдах авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 80,000,000.00 /наян сая/ төгрөгийн олон улсын онлайн сургалт худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол”-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт хийж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Их Сургуулийн ректор /Б.Очирхуяг/, Санхүү бүртгэлийн газрын дарга /Н.Халиун/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР     Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР     С.НАЦАГДОРЖ
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ     Д.ТОВУУДОРЖ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 817/А0150458 Улаанбаатар хот

САГ-2026/47/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн урсгал засварын тендерийн ерөнхий өгөгдлийн шаардлагад ажилласан жилийн туршлага 1 жил болон түүнээс дээш жил байх, тусгай зөвшөөрөлтэй байх гэсэн шаардлагуудыг хангаагүй байгууллагыг сонгон шалгаруулж 38,518,617.00 /гучин найман сая таван зуун арван найман мянга зургаан зуун арван долоон/ төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана", Тендерийн өгөгдлийн хүснэгтийн 18.1 "Ажиллах хүчний нөөц шаардана-Тухайн албан тушаалд ажилласан жилийн туршлага 1 жил ба түүнээс дээш байх", 18.3 "Тусгай зөвшөөрөл шаардана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Их Сургуулийн ректор /Б.Очирхуяг/, Санхүү бүртгэлийн газрын дарга /Н.Халиун/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ

МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.ТОВУУДОРЖ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-52.Docx

1526181107

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 818/А0150458 Улаанбаатар хот

САГ-2026/47/ИА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн эрдэм шинжилгээний инновацын нэгж, бүрэлдэхүүн 17 сургуульд олон улсын санхүүжилттэй 197 төсөл, дотоодын санхүүжилттэй 64 төсөл хэрэгжиж байгаа боловч төслийн RPMS программд төслүүдийг нэгтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8 “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гадаад, дотоодын санхүүжилттэй төслүүдийг RPMS программд нэгтгэхгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Их Сургуулийн ректор /Б.Очирхуяг/, Санхүү бүртгэлийн газрын дарга /Н.Халиун/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ТОВУУДОРЖ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-52.Docx

1526181103